



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хархорин сумын Ерөнхий боловсролын “Номын хүрдэн” сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ӨВА-2022/81/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Арвайхээр 2022 он</p>	<p>Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: О.Батжаргал Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn Аудитын менежер: Д.Гансүх Утас: 70323833 Цахим хаяг: GansukhD@audit.gov.com Аудитор: Р.Энхзул Утас: 70323833 Цахим хаяг: EnkhzulR@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Аудитын тайлан .....
- 3.1 Ерөнхий зүйл .....
- 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
- 3.4 Материаллаг байдал.....
- 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....
- 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....
- 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....
- 3.8 Аудитын гол асуудал.....
- 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....
- 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
- 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
4. Аудитын илрүүлэлт.....
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

## 1. Аудитын дүгнэлт



### ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,  
Утас/Факс: (976) 7032 3253,  
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

\_\_\_\_\_ № \_\_\_\_\_  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

ХАРХОРИН СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН "НОМЫН ХҮРДЭН"  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
П.ЭРДЭНЭБААТАР ТАНАА

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хархорин сумын Ерөнхий боловсролын "Номын хүрдэн" сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хархорин сумын Ерөнхий боловсролын "Номын хүрдэн" сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

D:\Auditin gazar\baiguullagiin dotood barimt\A4

015030418

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /төгрөгөөр/

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,582,540.00</b>	<b>8,794,131.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	401.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	401.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	5,582,540.00	8,793,730.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	27,200.00	962,518.00
35130	Эм боох материал	27,200.00	962,518.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	5,555,340.00	7,831,212.00
35410	Бичиг хэргийн материал	1,608,760.00	1,704,310.00
35420	Аж ахуйн материал	837,500.00	2,984,500.00
35440	Түлш, шатах тослох материал	288,000.00	776,000.00
35450	Барилгын засварын материал	1,174,000.00	-
35460	Хүнсний материал	1,647,080.00	2,366,402.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,801,044,299.76</b>	<b>2,979,838,991.78</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,801,044,299.76	2,979,838,991.78
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,800,310,966.46	2,979,281,658.52
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,841,711,414.00	2,982,471,926.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(61,390,380.48)	(96,838,739.52)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	11,311,176.00	37,667,433.48
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,051,666.72)	(3,125,176.93)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,579,000.00	63,144,600.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,904,566.34)	(6,590,452.79)
39217	Ном	55,990.00	2,552,068.28
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	733,333.30	557,333.26
39301	Програм хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(146,666.70)	(322,666.74)
<b>3</b>	<b>НИИТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,806,626,839.76</b>	<b>2,988,633,122.78</b>
<b>4</b>	<b>НИИТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>880,000.00</b>	<b>3,670,888.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	880,000.00	3,670,888.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	880,000.00	3,670,888.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	3,670,888.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	880,000.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	880,000.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,805,746,839.76</b>	<b>2,984,962,234.78</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,805,746,839.76	2,984,962,234.78
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,805,746,839.76	2,984,962,234.78
51210	Өмнөх үеийн үр дүн	1,830,611,223.88	1,805,746,839.76
51220	Тайлант үеийн үр дүн	(24,864,384.12)	1,179,215,395.02
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,806,626,839.76</b>	<b>2,988,633,122.78</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>291,756,566.00</b>	<b>1,729,754,098.76</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>13,847,166.00</b>	<b>1,156,739,147.76</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	13,847,166.00	1,156,739,147.76
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө	13,847,166.00	1,156,632,847.76
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал	-	106,300.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>277,909,400.00</b>	<b>573,014,951.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	178,853,900.00	424,475,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	178,853,900.00	424,475,100.00

Хархорин сумын Ерөнхий боловсролын "Номын хүрдэн" сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	2,093,600.00	11,692,451.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	2,093,600.00	817,451.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	10,875,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	96,961,900.00	136,847,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	96,961,900.00	136,847,400.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>316,620,950.12</b>	<b>550,538,703.74</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>316,620,950.12</b>	<b>550,538,703.74</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	309,105,337.77	524,951,821.33
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	148,561,894.44	273,459,597.00
210101	Үндсэн цалин	112,595,433.44	213,242,251.02
210102	Нэмэгдэл	23,153,226.00	46,558,387.98
210104	Урамшуулал	12,813,235.00	13,658,958.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	18,720,313.21	34,863,319.59
210201	Тэтгэврийн даатгал	12,774,687.61	24,323,753.29
210202	Тэтгэмжийн даатгал	1,502,902.47	2,739,623.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,202,313.39	2,191,698.91
210204	Ажилгүйдлийн даатгал	290,352.80	532,291.08
210205	Эрүүл мэндийн даатгал	2,950,056.94	5,075,952.76
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	88,436,783.00	139,613,288.00
210301	Гэрэл, цахилгаан	2,348,110.00	6,853,803.00
210302	Түлш, халаалт	80,546,743.00	119,720,445.00
210303	Цэвэр, бохир ус	5,541,930.00	13,039,040.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	11,364,237.00	3,006,109.00
210401	Бичиг хэрэг	294,040.00	1,172,669.00
210402	Тээвэр, шатахуун	1,086,107.00	1,311,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	100,000.00	393,040.00
210404	Ном, хэвлэл	61,660.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,822,430.00	128,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	3,278,920.00	25,703,120.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	36,000.00	393,192.00
210502	Хоол, хүнс	3,242,920.00	25,234,928.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	75,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,826,000.00	5,652,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		10,400.00
210604	Урсгал засвар	3,826,000.00	5,642,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	129,900.00	129,900.00
210702	Дотоод албан томилолт	129,900.00	129,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	260,200.00	110,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	260,200.00	110,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	34,527,090.12	42,413,887.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	89,100.00	818,082.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	468,100.00	1,212,050.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	33,969,890.12	40,383,755.74
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	7,515,612.35	25,586,882.41
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	280,000.00	8,140,350.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	7,860,350.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	280,000.00	280,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	3,710,495.35	17,446,532.41
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,710,495.35	17,446,532.41
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	3,525,117.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,525,117.00	
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(24,864,384.12)</b>	<b>1,179,215,395.02</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(24,864,384.12)</b>	<b>1,179,215,395.02</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,805,746,839.76	0.00	1,805,746,839.76
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	1,805,746,839.76	0.00	1,805,746,839.76
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,805,746,839.76	0.00	1,805,746,839.76
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,805,746,839.76	0.00	1,805,746,839.76
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	1,805,746,839.76	0.00	1,805,746,839.76
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,179,215,395.02	0.00	1,179,215,395.02
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,984,962,234.78	0.00	2,984,962,234.78

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	277,909,400.00	573,014,951.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	277,909,400.00	573,014,951.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	178,853,900.00	424,475,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	178,853,900.00	424,475,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,093,600.00	11,692,451.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,093,600.00	817,451.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	10,875,000.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	96,961,900.00	136,847,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	96,961,900.00	136,847,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	275,951,400.00	510,469,351.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	275,951,400.00	510,469,351.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	268,435,787.65	481,642,818.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	148,561,894.44	273,459,998.00
210101	Үндсэн цалин	112,595,433.44	213,242,652.02
210102	Нэмэгдэл	23,153,226.00	38,388,461.98
210104	Урамшуулал	12,813,235.00	21,828,884.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,720,313.21	34,863,319.59
210201	Тэтгэврийн даатгал	12,774,687.61	24,069,993.29
210202	Тэтгэмжийн даатгал	1,502,902.47	2,739,623.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,202,313.39	2,191,698.91
210204	Ажилгүйдлийн даатгал	290,352.80	532,291.08
210205	Эрүүл мэндийн даатгал	2,950,056.94	5,329,712.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88,436,783.00	135,942,400.00
210301	Гэрэл, цахилгаан	2,348,110.00	6,853,803.00
210302	Түлш, халаалт	80,546,743.00	116,049,557.00
210303	Цэвэр, бохир ус	5,541,930.00	13,039,040.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,968,897.00	3,935,909.00
210401	Бичиг хэрэг	121,200.00	1,167,469.00
210402	Тээвэр, шатахуун	1,374,107.00	1,799,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	100,000.00	393,040.00
210404	Ном, хэвлэл	61,660.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	311,930.00	575,600.00

Хархорин сумын Ерөнхий боловсролын "Номын хүрдэн" сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	4,735,800.00	23,823,292.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	63,200.00	1,033,692.00
210502	Хоол, хүнс	4,597,600.00	22,714,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	75,000.00	75,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,000,000.00	6,108,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	10,200.00
210602	Тавилга	-	1,143,200.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	4,955,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	129,900.00	129,900.00
210702	Дотоод албан томилолт	129,900.00	129,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,</b>	260,200.00	986,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	260,200.00	106,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	880,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	622,000.00	2,393,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	89,100.00	1,360,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	532,900.00	1,032,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>7,515,612.35</b>	<b>28,826,532.41</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	280,000.00	11,380,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	11,100,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	280,000.00	280,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	3,710,495.35	17,446,532.41
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,710,495.35	17,446,532.41
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	3,525,117.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,525,117.00	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>1,958,000.00</b>	<b>62,545,600.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>1,958,000.00</b>	<b>62,545,600.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,958,000.00</b>	<b>62,545,600.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	1,958,000.00	62,545,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,958,000.00	62,545,600.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(1,958,000.00)</b>	<b>(62,545,600.00)</b>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	564,322,500.00	543,875,967.59
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	564,322,500.00	543,875,967.59
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	552,942,500.00	532,495,967.59
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	267,180,300.00	268,256,398.00
210101	Үндсэн цалин	116,784,100.00	208,039,052.02
210102	Нэмэгдэл	127,763,800.00	38,388,461.98
210104	Урамшуулал	22,632,400.00	21,828,884.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	52,564,200.00	34,041,919.59
210201	Тэтгэврийн даатгал	36,304,600.00	23,248,593.29
210202	Тэтгэмжийн даатгал	4,064,900.00	2,739,623.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,251,900.00	2,191,698.91
210204	Ажилгүйдлийн даатгал	813,000.00	532,291.08
210205	Эрүүл мэндийн даатгал	8,129,800.00	5,329,712.76
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	131,892,400.00	131,892,400.00
210301	Гэрэл, цахилгаан	9,447,600.00	6,853,803.00
210302	Түлш, халаалт	108,229,400.00	111,999,557.00
210303	Цэвэр, бохир ус	14,215,400.00	13,039,040.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,519,300.00	3,519,100.00
210401	Бичиг хэрэг	621,200.00	1,050,660.00
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	1,499,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	400,700.00	393,040.00
210404	Ном, хэвлэл	109,500.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	887,900.00	575,600.00

**Хархорин сумын Ерөнхий боловсролын "Номын хүрдэн" сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	26,122,800.00	23,122,650.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	333,200.00	333,050.00
210502	Хоол, хүнс	25,714,600.00	22,714,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	75,000.00	75,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	59,925,000.00	59,925,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	22,970,000.00	22,970,000.00
210602	Тавилга	32,000,000.00	32,000,000.00
210604	Урсгал засвар	4,955,000.00	4,955,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	129,900.00	129,900.00
210702	Дотоод албан томилолт	129,900.00	129,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураа</b>	986,600.00	986,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний т	106,600.00	106,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	880,000.00	880,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	10,622,000.00	10,622,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,089,100.00	10,089,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	532,900.00	532,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	11,380,000.00	11,380,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	11,380,000.00	11,380,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,100,000.00	11,100,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	280,000.00	280,000.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>11,575,642.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>11,575,642.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		11,575,642.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		5,203,600.00
210101	Үндсэн цалин		5,203,600.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		821,400.00
210201	Тэтгэврийн даатгал		821,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		4,050,000.00
210302	Түлш, халаалт		4,050,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		416,809.00
210401	Бичиг хэрэг		116,809.00
210402	Тээвэр, шатахуун		300,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>		583,833.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		583,833.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		500,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		11,575,642.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		11,575,642.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		11,575,642.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		11,575,642.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		700,642.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		10,875,000.00

**3. Аудитын тайлан**

**3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хархорин сумын Ерөнхий боловсролын “Номын хүрдэн” сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц

бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитыг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Р.Энхзул гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Хархорин сумын Ерөнхий боловсролын "Номын хүрдэн" сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймгийн Аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 07 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Хархорин сумын Ерөнхий боловсролын "Номын хүрдэн" сургуулийн зорилго нь сурагчдын хөгжил төлөвшил сургалтын чанарыг ахиулж эвсэг нийтэч чадварлаг хамт олон бүрдүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд тус байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хархорин сумын Ерөнхий боловсролын "Номын хүрдэн" сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 550538.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 5505.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80.0 хувь буюу 4404.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө болон бараа материалын тодруулгыг бэлтгэжээ:

- Үндсэн хөрөнгө оны эхнээс 1219178.4 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан 62,545.6 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, үнэ төлбөргүй хүлээн авсан 1,156,632.8 мянган төгрөгөөр машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, номын фонд өссөнтэй холбоотой байна.
- Бараа материал оны эхнээс 3211.2 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан эм боох материал, аж ахуйн материал, хүнсний материал нэмэгдсэнтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Төсвийн төслийг хуулийн хугацаанд бэлтгэж, БСУГ-т нэгтгүүлж ирсэн байна. 2021 оны төсвийн төсөлд нийт зардлыг 1,307,693.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн ба санхүүжилт 605844.0 мянган төгрөгөөр батлагджээ.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайланд оны төсөв 605844.5 мянган төгрөгөөр батлагдаж, 41522.0 мянган төгрөгөөр хасагдаж 564322.5 мянган төгрөгийн санхүүжилт ирсэн ба үүнээс 20446.5 мянган төгрөгийн хэмнэлтийг буцаан төвлөрүүлжээ. Тайлант оны нийт төсвийн гүйцэтгэл 543876.0 мянган төгрөг байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 700.6 мянган төгрөгийг, сургалтын төлбөрийн орлого 10875.0 мянган төгрөгийг нийт 11575.6 мянган төгрөгийг санхүүжүүлэн үндсэн цалинд 5203.6 мянган төгрөг, тэтгэврийн даатгалын шимтгэлд 821.4 мянган төгрөг, түлш халаалтад 4050.0 мянган төгрөг, бичиг хэрэгт 116.8 мянган төгрөг, тээвэр шатахуунд 300.0 мянган төгрөг, эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэлд 583.8 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 500.0 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

### **3.8 Аудитын гол асуудал**

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим, сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэхэд жирэмсний болон амаржсаны амралттай албан хаагчийг 01 кодоор буруу тайлагнасан, шинээр нийт 62545.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан бөгөөд үүний 52575.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөд худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй зөрчил илэрлээ.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хархорин сумын Ерөнхий боловсролын "Номын хүрдэн" сургууль нь шилэн дансны цахим хуудсанд нийт 149 мэдээлэл байршуулахаас хугацаа болоогүй 1 мэдээлэл, 148 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.



Хархорин сумын Ерөнхий боловсролын "Номын хүрдэн" сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1	Хархорин сумын Ерөнхий боловсролын "Номын хүрдэн" сургууль	2	53415.6					2	53415.6		
---	--	---	---------	--	--	--	--	---	---------	--	--

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

Р.ЭНХЗУЛ

